



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар

A/532

Хэрлэн сум

Сургуулийн нээлтийн үйл ажиллагаанд
зориулан дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, дахь заалт Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3.2 дахь зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор Батноров сумын Бэрх хотын Кембрижийн олон Улсын ерөнхий боловсролын стандарттай сургуулийн нээлтийн үйл ажиллагаанд зориулан 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Document Захирамж-2022
23101120